



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976) 32 49 77,
E-mail: doc@nema.mn; http://www.nema.gov.mn

2017.06.02 № 7/1084

танай _____ -ны № _____ -т

Үүрэг хүргүүлэх тухай

“Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын Хорт хий, утаанаас хамгаалах талаар дагаж мөрдөх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар “Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм” нэртэйгээр баталсан.

Шинэчлэгдэн батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тул төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нар бэлтгэл ажлыг ханган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг үүгээр мэдэгдье.

Дүрмийн талаарх мэдээллийг Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, хошууч Г.Галбадрахаас тодруулна уу. Утас: 89118002, 263551

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА



С.ЗАЛУУХҮҮ



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/134

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. “Онцгой байдлын байгууллагын хэмжээнд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 509 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

600901372

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2017 оны 46 дугаар сарын 02-ны өдрийн
А/ВЧ 4 дугаартулаалын хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ДҮРЭМ

Зорилго: Онцгой байдлын байгууллагын албан хаагчид гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллах, дадлага сургуульд хамрагдах үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллахад үүсэх харилцааг зохицуулах, бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангахад оршино.

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүний эрүүл мэндэд аюултай хортой хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй, амьсгалахад хүндрэлтэй болон утаатай орчинд гал түймэр унтраах, эрэн хайх аврах ажиллагаа явуулах, дадлага сургууль зохион байгуулах үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй (АБДТ) албан хаагчдыг хамруулна.

2. Амьсгалын бие даасан төхөөрөмжөөр гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэдэг Онцгой байдлын байгууллагын албан хаагч нэг бүр хангагдсан байна.

3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг албан хаагч нэг бүрт бүртгэлээр хариуцуулна.

4. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах албан хаагч нь хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын иж бүрэн хувцастай байна.

5. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

5.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг.

5.2. Аюулгүй байдлыг хангах хэсэг.

5.3. Шалган зааварлах хэсэг.

6. Аймаг, нийслэлийн Онцгой байлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Гал түймэр унтраах аврах анги, Уул уурхайн аврах анги, Аврах анги, салбарын дэргэд амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэг ажиллана.

6.1. Орон нутгийн Онцгой байдлын газрын бүсийн төв, нийслэлийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах анgid амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төв байна.

6.2. Гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, бүлэг, салбарын дэргэд амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг байна.

7. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага сургуулийг мэргэжлийн өндөр түвшинд явуулах зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангиуд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага, сургалтын тусгай тоноглол бүхий талбайтай байна.

8. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагч нар гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага, сургалтыг хагас жилд нэгээс доошгүй удаа зохион явуулсан байна.

9. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагчид жил бүр хоёроос доошгүй удаа эрүүл мэндийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдан, эмнэлгийн дүгнэлт гаргуулж, амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн хувийн карт дээр тэмдэглэл хийж баталгаажуулсан байна. Үүнд:

Сүрьеэ
Мэдрэл
Дотор
Зүрх судас
Мэс засал
Чих, хамар, хоолой
Нүд
Арьс өнгө

10. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагч нэг бүрийг эмнэлгийн үзлэгт хамруулах ажлыг нийслэлийн Онцгой байдлын газар, аймгийн Онцгой байдлын газар, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагч нар шууд хариуцан зохион байгуулна.

11. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагч нь АБДТ-тэй ажиллах анхан шатны буюу давтан сургалтад тусгай хөтөлбөрийн дагуу заавал хамрагдана. Сургалтад хамрагдаагүй болон эмнэлгийн дүгнэлт гаргуулж, амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшихээр зөвшөөрөгдөөгүй албан хаагч нарт амьсгалын бие даасан төхөөрөмж олгох, эзэмшүүлэхийг хориглоно.

12. Томилгоот ээлжинд тогтмол гардаггүй боловч амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмших хуваарьт орсон албан хаагч улирал тутам нэгээс доошгүй удаа тусгай тоноглол бүхий талбайд болон ердийн орчинд 3-аас доошгүй цагийн дадлага, сургууль заавал хийсэн байна.

13. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх Аврах тусгай анги, Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, Уул уурхайн аврах анги, эрэн хайх аврах анги, салбаруудын албан хаагчдыг удирдан ажиллах даргалах бүрэлдэхүүн хагас жилд нэг удаа амьсгалын бие даасан төхөөрөмжтэй 3-аас доошгүй цагийн дадлага, сургуульд хамрагдана.

Хоёрдугаар бүлэг
Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах
хэсгийн зохион байгуулалт.

Нэг. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг.

1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүний эрүүл мэндэд хортой хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй амьсгалахад хүндрэлтэй орчинд ажиллах анхны нэгж нь амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг байна.

1.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийг хэсгийн ахлагчийг оролцуулан нэг төрлийн төхөөрөмжтэйгээр гурваас таван албан

хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж болох ба эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр хэсгийн бүрэлдэхүүнийг хоёроор нэмэгдүүлж болно.

1.3. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүнийг аврах ажиллагааны болон гал түймэр унтраах үйл ажиллагаанд биечлэн оролцдог нэг салаа, бүлгийн албан хаагчдаас бүрдүүлэн шаардлагатай тохиолдолд өөр салаа, бүлгийн аврагч, гал сөнөөгчдийг гал түймэр унтраах удирдагч, эрэн хайх, аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр оролцуулж болно.

1.4. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллаж байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийг дараах албан тушаалтан удирдан ажиллуулна.

1.4.1. Нэг тасаг, бүлэг ажиллаж байгаа үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн даргаар салааны захирагч, бүлгийн дарга, түүний шийдвэрээр томилогдсон туршлагатай гал сөнөөгч, аврагч.

1.4.2. Хэд хэдэн тасаг, бүлэг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллах үед эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн тушаалаар томилогдсон албан хаагч.

1.4.3. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэгтэй хамт голомтод орж ажиллавал уг албан тушаалтан.

1.5. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулагдсан амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүн нь ослын үед хэрэглэх нэмэлт салаалагч бүхий амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллана.

1.6. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсгийн албан хаагчдаас хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд хэсэг яаралтай цэвэр агаарт гарах ажиллагааг эхлүүлэх, анхны тусlamж үзүүлэх, шаардлагатай бол эмчийн хяналтад өгч, аюулгүй байдлыг хангах хэсэг, шалган зааварлах хэсэгт болсон асуудлын талаар мэдэгдэнэ.

1.7. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэг нь бүрэн бүрэлдэхүүнээрээ голомтоос гарах ба ямар нэгэн шалтгаанаар албан хаагч үлдээхийг хориглоно.

1.8. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг утаатай орчинд хайгуул хийхдээ дараах багаж хэрэгслийг авч явна. Үүнд:

- 1.8.1. Аврах олс.
- 1.8.2. Гэрэлтүүлэх хэрэгсэл.
- 1.8.3. Холбооны хэрэгсэл.
- 1.8.4. Задаргаа хийх гар багаж.
- 1.8.5. Хушуу, хоолой.
- 1.8.6. Дулаан мэдрэгч камер.
- 1.8.7. Агаар дахь хүчилтөрөгч, хорт, хий утааг тодорхойлох багаж.

Хоёр. Аюулгүй байдлыг хангах хэсэг

2.1. Аюулгүй байдлыг хангах хэсэг нь амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах албан хаагчдын аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

2.2. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллаж байгаа үед эрэн хайх аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, гал

түймэр унтраах шуурхай штабын дарга, шалган зааварлах хэсгийн дарга нар, дадлага, сургуулийн үед сургуулийн удирдагч нар аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийг тухайн үеийн цагийн байдалтай уялдуулан томилж ажиллуулна.

2.3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн цагийн байдал хүндэрсэн үед нэмэлт ажиллагаанд оролцох амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэд, хэдэн тасаг, бүлгийг зохион байгуулж бэлэн байдлыг хангана.

2.4. Нэмэлт ажиллагаанд оролцох хэсгийн албан хаагчдын агаар хадгалах савны нөөц 80 хувиас доошгүй байна.

Гурав. Шалган зааварлах хэсэг

3.1. Удаан хугацаагаар үргэлжилсэн гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хэд хэдэн хэсгүүд ажиллаж байвал авралтын ажиллагааны дарга, гал түймэр унтраах удирдагч нар нь шалган зааварлах хэсгийг зохион байгуулна.

3.2. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч нь шалган зааварлах хэсгийн даргаар офицер албан хаагчийг томилно. Шалган зааварлах хэсгийн даргын удирдлагад хүрэлцэхүйц тооны албан хаагчдыг томилон ажиллуулна.

3.3. Шалган зааварлах хэсгийн дарга, эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч болон гал түймэр унтраах удирдагчид, ажиллагааг удирдах штаб, гал түймэр унтраах шуурхай штаб зохион байгуулагдсан бол штабын даргад шууд захирагдана. Штабын даргын тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгүүдийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллана.

3.4. Шалган зааварлах хэсгийн байранд дараах зүйлс зайлшгүй байвал зохино. Үүнд:

3.4.1. Таваас доошгүй нөөц амьсгалын бие даасан төхөөрөмж.

3.4.2. Агаар хадгалах сав, бусад сэлбэгийн нөөц.

3.4.3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг шалгах тусгай зориулалтын хэрэгсэл.

3.4.4. Иж бүрэн тусгай түлхүүр, багаж.

3.4.5. Халуун цай, аарц, чацаарганы шүүс.

3.4.6. Анхны тусlamжийн иж бүрдэл.

3.4.7. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн арчилгаа үйлчилгээний бодис, материал (цэвэрлэх, ариутгах, тослох, үл цантуулагч бодис)

Тайлбар: Цаг агаарын болон хүндрэлтэй нөхцөлд ажилласан бие бүрэлдэхүүний бие, эрүүл мэндийн байдалд өөрчлөлт орохоос урьдчилан сэргийлж, шалган зааварлах хэсгийн дарга нь тусгаарлах өрөө буюу байр бэлтгэж байрлуулна.

Дөрөв. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэг

4.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төвийг Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагч, засварын хэсгийг Гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, салбарын дарга, захирагч нар удирдаж ажиллана.

4.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэг нь хуваарыт байгаа нийт амьсгалын бие даасан төхөөрөмжийг

хариуцан шалгах, засварлах, цэвэрлэх, ариутгах, тослох, зааварлах, баримт бичгийг хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төвд АБДТ хариуцсан ахлах засварчин, засварын хэсэгт АБДТ хариуцсан засварчин ажиллана.

4.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, хэсэг нь хадгалах, шалгах зориулалт бүхий тусгай тоноглогдсон ширээ, тусгай зориулалтын багаж хэрэгсэл, хуваарьт байгаа төхөөрөмж, агаар хадгалах сав, битүүмжлэл шалгах тестэр, сэлбэг хадгалах тавиур амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийг хатаах шүүгээ бүхий өрөө, агаар хадгалах савыг цэнэглэх өрөө зэргээс бүрдэнэ.

4.5. Агаар хадгалах савыг цэнэглэх өрөөнд агаар хадгалах савыг цэнэглэх сургалтанд хамрагдсан албан хаагч, засварчнаас өөр хүн орохыг хатуу хориглоно.

4.6. Нүүрний хамгаалах багийг ариутгах уусмалд (30°C -ийн) 15 минут, хатаах өрөөний агаарын дулааны дээд хэмжээ 60°C , $3^{\circ}\text{C}-25^{\circ}\text{C}$, нарны шууд тусгалаас хол, дулааны үйлчлэлээс хамгаалах шаардлагатай.

4.7. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төвийн өрөө тасалгаанууд агаарын стандартын шаардлага хангасан байх ба засвар үйлчилгээний төв, хэсгийн өрөө тасалгааны аюулгүй ажиллагааны журам боловсруулан батлуулж мөрдлөг болгон ажиллах.

4.8. Агаар хадгалах савыг цэнэглэх өрөө 16 m^2 -аас багагүй, агаар сэлгэх салхивчтай байна. Агаар хадгалах цэнэгтэй савыг нарны шууд тусгал, дулааны үйлчлэлээс хол, тоос шороо чийгнээс хамгаална. Цэвэрлэх, ариутгах өрөө нь угаалтуур, хатаагч шүүгээ зэргээс бүрдэл болно.

Гуравдугаар бүлэг

Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалтын талаар

албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

Нэг. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс,

Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагчийн үүрэг

1.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн захирагч нар амьсгалын бие даасан төхөөрөмж түүний ашиглалтын засвар үйлчилгээний төв, хэсгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цэвэрлэгээ, ариутгал, тосолгоо, үл цантуулах тусгай бодис материалын нөхөн хангалтын асуудлыг шууд хариуцна.

1.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах онолын болон дадлагын сургалт, амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалтын засвар үйлчилгээний төвийг бэхжүүлэх талаар шаардагдах зардлыг төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1.3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдын амьсгалын бие даасан төхөөрөмжийн аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавина.

Хоёр. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан мэргэжилтний үүрэг

2.1. Бие бүрэлдэхүүний амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах талаар шат дараалсан сургалт, засвар үйлчилгээний төв, хэсэг, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл шалгах хэсгийн үйл ажиллагаа, 4 төрлийн шалгалтын явц, бүртгэл, баталгаажуулалтанд 6 дугаар бүлэгт заасан хугацааны дагуу хяналт тавих.

2.2. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшдэг албан хаагчдыг утаатай, үзэгдэх орчин хязгаарлагдмал, биеийн хүч шаардсан, хүндруулсэн нөхцөлд бэлтгэн дадлагажуулах, гал сөнөөгч, аврагчдын нэгдсэн цугларалтын үед анхан шатны болон давтан сургалтыг явуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

2.3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэх, сургалт дадлагын явцад холбогдох дүрмүүдийн заалт болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт тавих.

Гурав. Гал түймэр унтраах аврах анги, Аврах ангийн захирагчийн үүрэг

3.1. Гал түймэр унтраах аврах анги, Аврах ангийн захирагч нь хариуцсан ангийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн бэлэн байдал, бүрэлдэхүүний дадлага, сургалтын ажлыг шууд хариуцна.

3.2. Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний бурдэл хэсэг агаар хадгалах савны хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангуулах.

Дөрөв. Салааны захирагч, бүлгийн даргын үүрэг

4.1. Салаа, бүлгийн бүрэлдэхүүнийг сургалт, дадлагын батлагдсан хөтөлбөрийн дагуу сургаж, дадлагажуулах.

4.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн шалгалтуудыг тогтоосон хугацаанд зааврын дагуу хийлгэж, засварт орох төхөөрөмжийг засвар үйлчилгээний төв, засварын хэсэгт өгч шалгуулах.

4.3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэсний дараа хийх шалгалт, үйлчилгээг энэ дүрэм болон амьсгалын бие даасан төхөөрөмжийн үйлдвэрийн зааврын дагуу хийх.

4.4. Нөөцөнд байгаа агаар хадгалах сав, аврах ажиллагааны болон гал түймэр унтраах зориулалтын автомашин, засварын хэсэгт байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах.

4.5. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүнийг зохион байгуулж аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Тав. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчны үүрэг

5.1. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин нь амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах анги, Гал түймэр унтраах аврах ангийн захирагч, аврах ажиллагаа, гал түймэр унтраах үед эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, шалган зааварлах хэсгийн даргад захирагдана. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин нь дараах үүргийг хариуцан гүйцэтгэнэ. Үүнд:

5.1.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн төрөл бүтэц, үйлчилгээ, шалгалт хийх журам, төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийг мэргэжлийн өндөр түвшинд бүрэн эзэмшиж мэдсэн байна.

5.1.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэгт байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүчин чадлын дагуу бүрэн дүүрэн хэрэглэж чаддаг байх.

5.1.3. Засвар үйлчилгээний төв, хэсгийг энэ дүрмэнд заасны дагуу зохион байгуулах.

5.1.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалт, хадгалалтад тогтмол хяналт тавьж, өөрийн харьялалд байгаа Аврах тусгай анги, Уул уурхай аврах анги, Гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, салбарын амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчдийг сургах, дадлагажуулах ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллах.

5.1.5. Амьсгалын бие даасан төхөөрөмжид жилд нэг удаа бүрэн засвар, үйлчилгээ хийж бэлтгэл, бэлэн байдлыг хангуюлах.

5.1.6. Засвар үйлчилгээний төв, хэсгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн бүтэн байлгаж, хэрэглэх үед аюулгүй ажиллагааны шаардлагыг сахиулж, амьсгалын бие даасан төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бүртгэлийн баримт бичгийг үнэн зөв баталгаажуулан хөтлөх.

5.1.7. Агаар хадгалах савны нөөцийг бэлтгэх, шаардлагатай бол турших, шалгуулахаар шинжилгээнд явуулж дүгнэлт гаргуулах, 5 жилд нэг удаа агаар хадгалах савыг стандарт шаардлага хангасан эсэхийг туршиж иж бүрэн шалгалтанд оруулах.

5.1.8. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн гуравдугаар шалгалт хийх жилийн график төлөвлөгөөний хуваарийг гаргах, шалгалт хийх, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагаатай эсэхийг улирал бүр шалган энэ тухай техникийн-үзлэгийн тэмдэглэл хөтлөн, материалжуулах.

5.1.9. Томоохон хэмжээний гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллах үед шаардлагатай тооны агаар хадгалах цэнэгтэй сав, амьсгалын бие даасан төхөөрөмжийг төвлөрүүлэн ажиллах.

5.1.10. Жил бүр агаарын шахуурга, амьсгалын бие даасан төхөөрөмжийн хэвийн байдлыг шалгаж үнэлгээ дүгнэлт өгч техникийн үзлэгийн тэмдэглэл хөтлөн, удирдах албан тушаалтанд танилцуулах, шийдвэрлүүлэх.

Зургаа. Шалган зааварлах хэсгийн даргын үүрэг

6.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аврах болон гал түймэр унтраах ажиллагааг зохион байгуулах талаар авралтын ажиллагааны дарга, гал түймэр унтраах удирдагчийн өгсөн үүрэг, тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулан мэргэжлийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх.

6.2. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд ажиллаж байгаа хэсгүүдийг тогтоосон хугацаанд нь солих ажиллагааг хангахын дээр ажиллаж, амарч байгаа болон бэлтгэлд байгаа хэсгүүдийн тооцоог гуравдугаар хавсралтын дагуу бүртгэх.

6.3. Аюулгүй байдлыг хангах хэсгүүд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэгтэйгээ байнгын холбоотой ажиллаж байгааг шалгаж, хэсгүүдийн амралтыг зохион байгуулах, хэсгүүдийн ажиллагааны талаар эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчид байнга илтгэх.

6.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг, агаар хадгалах сав, бусад сэлбэг, хэрэгслийн нөөцийг бий болгох.

6.5. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүрэлцэн ирсэн эмнэлгийн яаралтай тусlamж, эмчийн тусlamжтайгаар амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэг болон бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд хяналт тавьж ажиллах.

Долоо. Аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийн үүрэг

7.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүний хувийн зэвсэглэмж, бусад багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих.

7.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсгийн бүрэлдэхүүнтэй байнга холбоотой ажиллана. Хэрэв холбоо тогтоох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд хариуцсан даргадаа яаралтай мэдэгдэж, удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

7.3. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, хичээл зааж буй сургагч настай тогтмол холбоотой байх бөгөөд холбооны хэрэгсэлгүй үед холбоочинтой ажиллах.

7.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хорт хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй, амьсгалахад хүндрэлтэй орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжгүй буюу төхөөрөмжтэй боловч тухайн хэсгийн бүрэлдэхүүнд ороогүй албан хаагчдыг болон гадны хүнийг нэвтрүүлэхгүй байх.

7.5. Шалган зааварлах хэсгээс гаргасан амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах тооцооны дагуу голомтоос буцах дохиог амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэгт дамжуулах ба төхөөрөмжтэй ажилласан тооцооны бүртгэлийг хөтлөх.

Найм. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн ахлагчийн үүрэг

8.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхдээ аврагч, гал сөнөөгчдийг идэвх санаачлага, тэсвэр хатуужилтай, өгөгдсөн үүрэг, тушаалыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийн зэрэгцээ хэсгийн бүрэлдэхүүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах.

8.2. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аврах болон гал түймэр унтраах ажиллагааг явуулах үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийг хатуу баримтлан үүрэг гүйцэтгэх.

8.3. Өөрийн хариуцсан хэсгийн гүйцэтгэх үүргийг сайтар мэдэж, түүнийг биелүүлэх арга зүйг боловсруулж, амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хэсгийн ажиллах хугацаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар бүрэлдэхүүнд тайлбарлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

8.4. Эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагааны үед аврагч, гал сөнөөгчдийн хөдөлмөр хамгааллын хувцас, хувийн зэвсэглэмж, хэсгийн албан хаагчдын багаж хэрэгслийн иж бүрдлийг шалгах.

8.5. Хэсгийн бүрэлдэхүүнд шалган зааварлах хэсэг, аюулгүй байдлыг хангах хэсгийн байрлалыг зааж өгөх.

8.6. Хорт хий, утаа ялгарсан болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд орохын өмнө албан хаагч нэг бүрийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн агаар хадгалах саван дахь агаарын даралтыг шалгаж, ажиллах нийт хугацаа, голомтод ажиллах, буцах хугацааг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомт хүртэл явсан хэсгийн бүрэлдэхүүний хамгийн их агаар зарцуулалтаар тогтооно.

8.7. Аюулгүй байдлыг хангах хэсэгтэй байнга холбоо барьж түүгээр дамжуулан аврах ажиллагааны болон гал түймрийн нөхцөл байдал, хэсгийн үйл ажиллагааны талаар эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, шалган зааварлах хэсгийн даргад илтгэх.

8.8. Барилгын нурсан хийц бүтээц, утаа ихтэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал объектод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэж байгаа хэсгийн ахлагч буюу чиглүүлэгч урдах замаа задаргаа хийх гар багажаар тогших, буцах замаа судлах, шалгаж явах үүрэгтэй.

8.9. Хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгчдийн биеийн эрүүл мэндийн байдал, багаж хэрэгслийн ашиглалт, агаарын зарцуулалтад хяналт тавьж, голомтоос гарах тогтоосон хугацаа болмогц хэсгийн бүрэлдэхүүнийг цэвэр агаарт гаргах.

8.10. Хэсгийн бүрэлдэхүүнийг нүдэнд үзэгдэхүйц газарт буюу дуут дохио сонсогдох, хөдөлгөөн буюу байрлал тогтоогчид мэдэгдэхүйц, гэрэл, холбоо ашиглаж дохио өгч болох зайнд ажиллуулах.

8.11. Хэсгийн бүрэлдэхүүний хэн нэг нь үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон буюу аль нэг амьсгалын бие даасан төхөөрөмжинд алдаа заасан, бүрдэл хэсэг ажиллагаагүй болбол бүрэлдэхүүнээрээ гадагш цэвэр агаарт гарч энэ тухай эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчид нэн даруй илтгэх.

8.12. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж буй хэсгийн бүрэлдэхүүнийг цэвэр агаарт гаргаж амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүр хамгаалах багийг тайлах, агаар хадгалах савны хаалтыг хаах тушаал өгөх.

**Ес. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа аврагч,
гал сөнөөгчийн үүрэг**

9.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгч хэсгийн гүйцэтгэх үүрэг, төхөөрөмжтэй ажиллах хугацааг сайн мэдэж бүрэн биелүүлэх.

9.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байх үедээ хамт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч болон өөртөө анхаарал тавьж байнгын холбоотой ажиллаж, буцах замаа сайн тогтоож авах.

9.3. Хамт үүрэг гүйцэтгэж байгаа нөхөртөө тусламж үзүүлэхэд хэзээд бэлэн байж, ямар ч нөхцөлд хэсгийн ахлагчийн шийдвэргүй байрлалаа орхихгүй байх.

9.4. Цагийн байдлын талаарх өөрчлөлтийн тухай мэдээллийг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, өөрийн ажиллаж буй хэсгийн ахлагч нарт цаг алдалгүй тухай бүр нь илтгэж байх.

9.5. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг агаар хадгалах саван дахь агаарын зарцуулалтын тооцоог хийж чаддаг байхын зэрэгцээ даралт хэмжигчийн заалтаар даралтыг хянаж, шаардлагагүй үед ослын товчлуурыг хэрэглэхгүй байх.

9.6. Аюулгүй байдлыг хангах хэсэг, шалган зааварлах хэсгийн байрлалыг сайн мэддэг байх.

9.7. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүрний хамгаалах багийг тайлах, өмсөх үйлдлийг хэсгийн ахлагчийн шийдвэрээр ёсчлон дагаж биелүүлэх.

9.8 “Баг өмс” гэсэн тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүрний хамгаалах багийг өмсөнө. Энэ тушаалаар аврагч, гал сөнөөгч бүр дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

9.8.1. Хөдөлмөр хамгааллын иж бүрэн хувцсыг өмсөж амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүрний хамгаалах багийг нүүрэндээ суурьлуулан чангалсны дараа хүзүүвч бүхий дотуур малгайг өмсөж, дуулга малгайн сагалдаргыг чангалаан өмсөнө.

9.8.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэхдээ гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аль болох ойролцоо цэвэр агаартай газар өмсөх.

Дөрөвдүгээр бүлэг
Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй
ажиллах нийтлэг зарчим

1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүрний хамгаалах багийг өмсөөд гүн, жигд амьсалах хэрэгтэй. Хэрэв хүнд хүчир ажил хийж байхад амьсгал давхцах, жигд бус амьсалах, толгой эргэх, дотор муухайрах зэрэг өөрчлөлт орвол уг ажлыг түр зогсоож, хэд хэдэн удаа гүнзгий амьсгалж, амьсалаа хэвийн байдалд оруулах ба хэсгийн ахлагчид заавал мэдэгдэнэ.

2. Утаатай орчноос цэвэр агаарт гарах хүртэл нүүрний хамгаалах багийг тайлах, багийг авч харах цонхыг арчих, цэвэрлэх зэргийг хатуу хориглоно.

3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг зааврын дагуу зөв өмсөж хэрэглэнэ. Хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд нэн даруй хэсгийн ахлагчид мэдэгдэж, хэсэг цэвэр агаарт гарах хүртэл төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авна.

3.1. Амьсгалахад хүнд болж, биеийн ерөнхий байдал сулрах, толгой эргэх, шанааны судас хүчтэй цохих, агаар дутагдах зэрэг шинж тэмдэг илэрсэн үед ослын товчлуурыг дарж агаараар хангана.

3.2. Амьсгал авахад хүндрэлтэй байвал энэ нь агаараар хангах хавхлагны ажиллагаа хэвийн биш байна гэж үзэн ослын товчлуурыг үе үе дарах хэрэгтэй.

4. Хэсгийн ахлагчаас “Баг тайл” гэсэн тушаал өгөхөд хэсгийн бүрэлдэхүүн дуулга малгай болон хүзүүвч бүхий дотор малгайг авч нүүрний хамгаалах багийг тайлж, агаар хадгалах савны хаалтыг хаана.

5. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хайгуулын болон аврах ажиллагааг явуулах амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь хоолойн шугам дэлгэж хушуугаар ус өгөхөд бэлэн орж ажиллах.

6. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь дараах дэг журмыг хатуу сахих хэрэгтэй. Үүнд:

6.1. Чиглүүлэгчээр амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн ахлагч, цоожлогчоор хэсгийн туршлагатай албан хаагч явна. Ямар ч тохиолдолд цувж явах шаардлагатай. Цоожлогч хэсгийн хөдөлгөөний дэг журам болон бүрэлдэхүүний биеийн байдал, буцах замд хяналт тавьж байх үүрэгтэй. Буцах замд цоожлогч чиглүүлж харин хэсгийн ахлагч цоожлогчоор явна.

7. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хугацаанд төхөөрөмж хэрэглэгчид болон хэсгийн дарга нар даралт хэмжигчийн заалтыг тогтмол шалган үзэж байх үүрэгтэй.

7.1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэх үеийн нийт ажиллах хугацааг урьдчилан тооцоолж, хэсгийн албан хаагч нэг бүр голомтод ажиллах, буцах хугацааг мэдэж байх бөгөөд даралт хэмжигчийн заалтанд хяналт тавин ажиллах.

8. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь цэвэр агаартай орчинд ээлж солилцено. Гэхдээ эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажиллаж байгаа байранд солилцож болно. Амарч буй хэсэг нь нөөц хүч болж дараагийн ажилд бэлтгэнэ.

9. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч хорт хий, утаатай нөхцөлд ажиллах эхний үеэс нөөц хүчийг томилох буюу дуудах шийдвэрийг гаргана.

10. Олон хүний амь бие, эрүүл мэндэд аюул учирсан, аврах ажиллагааг яаралтай зохион байгуулах, бага хэмжээний объектод ажиллах шаардлага гарвал аврах зам гарц нь ойрхон тохиолдолд утаатай орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй бие бүрэлдэхүүнийг олон хэсэгт зохион байгуулан ажиллуулж болно.

11. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн нэмэгдэл хүч, шалган зааварлах болон аюулгүй байдлыг хангах хэсэгт үлдсэн албан хаагчид ямар ч үед утаатай орчинд ажиллаж байгаа албан хаагчдад тусlamж үзүүлэхэд бэлэн байх ёстой.

12. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд ажиллаж байгаа хэсгийн бүрэлдэхүүн хүнд байдалд орсон буюу холбоо тасарсан тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч нар нөөц хэсгийг нэн даруй явуулж тусlamж үзүүлнэ.

13. Хэсгийн ажиллах болон амрах хугацааг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр тогтооно.

14. Тэсрэх аюул бүхий хий, ууршилттай байранд аврах болон гал түймэр унтраах, хайгуулын ажлыг хийхдээ амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь резинэн гутал өмсөж, ямар нэгэн оч гарах багаж хэрэгслийг (цахилгаан гэрэлтүүлэг) хэрэглэхээс зайлсхийж, өндөр сонор сэргээж, анхааралтай ажиллана.

15. Хүйтний улиралд амьсгалын бие даасан төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах:

15.1 Амьсгалын бие даасан төхөөрөмжийг зөөвөрлөхдөө тусгай зориулалтын дулаалгатай хайрцганд буюу аврах ажиллагааны болон гал түймэр унтраах автомашины аврагч, гал сөнөөгчдийн бүхээгт авч явах ба нүүрний хамгаалах багны харах цонхонд үл цантуулагч заавал хэрэглэнэ.

15.2 Агаарын температур -25°C буюу амьсгалахад хүндрэлтэй байранд амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүрний хамгаалах багийг өмсөх, тайлах хүйтэн агаар гэнэт амьсгалах, хүйтэн шингэн зүйл уух зэргийг хатуу хориглоно.

15.3 Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүрний хамгаалах багийг зайлшгүй тайлах, өмсөх шаардлага гарвал хэсгийн ахлагчийн шийдвэрээр зөвхөн дулаан, хорт хий, утаагүй орчин, байранд гүйцэтгэнэ.

Тавдугаар бүлэг

Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний бүрдэл хэсгүүд болон сэлбэг, хэрэгслийг хадгалах, засварлах, агаар хадгалах савыг цэнэглэх.

1. Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний сэлбэгийг үйлдвэрийн аюулгүй байдлын зааврын шаардлагын дагуу зөв хадгалах, хэрэглэсний дараа цэвэрлэгээ, ариутгал, үйлчилгээг тогтмол хийж байх нь албан хаагчдын аюулгүй байдал, төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангана. Хадгалахдаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн өөрийнх нь нумарсан хэлбэрт барьж хадгалах ба агаар хадгалах савыг гадны үйлчлэлээс хамгаалсан, дулааны үйлчлэлд тэсвэртэй материалыар уут хийж дээр нь гэрэл ойлгогч байрлуулах.

2. Томилгоот ээлжийн хуваарьт болон нөөцөнд байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийг зөвлөн материалыаар доторлосон тусгай хайрцганд бэхэлгээтэйгээр байрлуулж хадгалах ба автомашинд авч явна.

3. Нүүрний хамгаалах багны нөөц холболттой амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэсгийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах болон авралтын ажиллагааны үед нэрвэгдэгсдэд хэрэглүүлэх.

4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн тусгай зориулалтын автомашингүй нэгж, агаар хадгалах нөөц сав, сэлбэг хэрэгслийг бэхэлгээтэй зөвлөвч бүхий тусгайлан бэлдсэн хайрцганд хийж гал түймэр унтраах автомашинд хадгалж, тээвэрлэнэ.

5. Агаар хадгалах савыг хадгалах, тээвэрлэхдээ хаалтыг бүрэн хаасан байх ба гал түймэр унтраах автомашинд бэхэлгээгүй тээвэрлэх, агаар хадгалах савыг хурц үзүүртэй зүйлээр цохих, хатуу гадаргуутай газар унагах, дүүрэн цэнэгтэй үед хэт халаах зэргийг хориглоно.

6. Томилгоот ээлжнээс буусан албан хаагч өөрийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн дугаартай тусгай шүүгээ буюу тавиур дээр хадгална. Хадгалах савыг цэнэгтэй, цэнэггүй, засварт гэсэн тэмдэглэл бүхий тусгай тавиур дээр хадгалах ба халаалт, дулааны системээс 1м-ээс доошгүй зйтай $+3^{\circ}\text{C}$ - $+25^{\circ}\text{C}$ - ийн дулаантай, стандартын шаардлага хангасан өрөөнд хадгална.

7. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан албан хаагч томилгоот ээлжинд гарах, буух, хэрэглэсний дараа дүрмэнд заагдсаны дагуу төхөөрөмж хэвийн ажиллагаатай эсэхийг шалгаж, цэвэрлэгээ, техникийн үйлчилгээг салааны захирагчийн удирдлагын дор хийнэ. Шаардлагатай үед засварчныг дуудаж үйлчилгээг хийхэд туслуулж болно.

8. Албан хаагч өөрөө амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг задалж засахыг хориглоно. Амьсгалын бие даасан төхөөрөмж, түүний бүрдэл хэсэгт гарсан гэмтлийг засварлах, шинээр эд ангийг солих ажлыг засвар үйлчилгээний төв, засварын хэсэг дээр ахлах болон засварчин хийнэ. Засвар үйлчилгээ хийлгэхээр өгөх, авах ажиллагааг төхөөрөмж эзэмшигч өөрөө буюу салааны захирагч хариуцан гүйцэтгэнэ.

9. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг угааж, цэвэрлэсний дараа хатааж угсралтад шалгалтыг хийнэ.

10. Засвар үйлчилгээний төв, засварын хэсэг нь хуваарьт байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн 30 хувьтай тэнцэх тооны агаар хадгалах савны нөөцтэй байх бөгөөд дөрөвний гурав нь бүрэн цэнэгтэй байна. Агаар хадгалах савыг аль болох бүрэн цэнэглэж, хэрэглэх үедээ 90 хувиас багагүй цэнэгтэй байлгана.

11. Агаар хадгалах савыг дараах байдлаар цэнэглэнэ:

11.1. Агаар хадгалах савыг цэнэглэх шахуургыг ажиллуулах сургалтад хамрагдсан амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин ажиллуулна.

11.2. Агаараар цэнэглэх шахуургыг цэвэр, хуурай, нарны гэрэл шууд тусдаггүй хэт халалт болохоос сэргийлж агаарын солилцоо сайтай газар сонгон байрлуулж ажиллуулна. Хорт хий, утаа ялгарсан тоос шороо ихтэй газар ажиллуулахыг хориглоно.


11.3. Агаараар оруулах холбоосуудыг сайтар холбон чангаж, агаараар цэнэглэх шахуургын тэнцвэрийг олж агаар хадгалах савыг хэвтээ байрлалд байрлуулна.

11.4. Төхөөрөмжийг ажиллуулагч гарч болзошгүй аюулаас сэргийлж унтраалгад аль болох ойрхон байж ажиллуулахаас гадна багаж, хэрэгслээр цохих, дээр нь суухыг хориглоно.

11.5. Агаар хадгалах савыг цэнэглэхдээ тухайн савны даралтын стандарт хэмжээнд тохицуулж агаар дүүргэх ба бүрэн цэнэглэсний дараа агаараар цэнэглэх шахуургын доторх агаарыг бүрэн гаргасны дараа агаар хадгалах савыг салгана.

11.6. Шахаж буй агаарын чийгшил их байвал агаар хадгалах саванд орох агаарын урсгалд саад болж агаар шахах шахуургын хүчин чадлыг бууруулдаг тул усны цоргыг нээж агаараас шүүгдсэн ус, чийгийг гадагшлуулах арга хэмжээг авна.

11.7. Агаараар цэнэглэх шахуургын агаар орох хоолой руу ус орохоос хамгаалах шаардлагатай.



Зургаадугаар бүлэг
Амьсгалын бие даасан төхөөрөмжинд хийх шалгалт

1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, ажиллагааны үеийн эрсдэлийг бууруулах, найдвартай ажиллагаатай эсэхийг тодорхойлохын тулд тухайн төхөөрөмжийг үйлдвэрлэсэн үйлдвэрийн техникийн засвар үйлчилгээ, ашиглалтын зааврын дагуу дор дурдсан шалгалтуудыг хийнэ.

- 1.1. Нэгдүгээр шалгалт
- 1.2. Хоёрдугаар шалгалт
- 1.3. Гуравдугаар шалгалт
- 1.4. АБДТ-ийг хэрэглэхийн өмнөх шалгалт

Нэгдүгээр шалгалт

2. Нэгдүгээр шалгалтыг томилгоот ээлжинд гарахын өмнө аврагч, гал сөнөөгч өөрийн биеэр салааны захирагчийн удирдлаган дор хийж гүйцэтгэнэ. Нэгдүгээр шалгалтаар илэрсэн гэмтлийг засварлах боломжгүй бол хоёрдугаар шалгалт хийх хуваарьт шилжүүлэх ба бэлтгэл, бэлэн байдлыг хангасан амьсгалын бие даасан төхөөрөмжөөс нөхөн хангальт хийнэ. Нэгдүгээр шалгалтын дараа төхөөрөмж эзэмшигч бүр салааны захирагчид шалгалтын дүнг илтгэж нэгдүгээр шалгалт хийсэн тухай бүртгэлд бичилт хийж баталгаажуулна.

Хоёрдугаар шалгалт

3. Хоёрдугаар шалгалтыг сард 1 удаа эсвэл их цэвэрлэгээ, ариутгал, үйлчилгээ, засвар хийсэн, 1 дүгээр шалгалтаар гэмтэл илэрсэн болон гуравдугаар шалгалтын дараа тус тус хийнэ. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймэр унтраах ажиллагаа буюу дадлага, сургуулийн явцад амьсгалын бие даасан төхөөрөмжийг шалгах, агаар хадгалах савыг цэнэглэх шаардлага гарвал төхөөрөмж эзэмшигчид шалган зааварлах хэсэг дээр очиж засварчин буюу хэсгийн даргын удирдлага дор хийж гүйцэтгэнэ.

Гуравдугаар шалгалт

4. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх, аврагч, гал сөнөөгчдийн хэрэглэж байгаа болон шинээр хүлээн авсан амьсгалын бие даасан бүх төхөөрөмжинд жилд нэгээс доошгүй удаа 3 дугаар шалгалт хийнэ.

5. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн 3 дугаар шалгалтыг амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин нар чиглэл хариуцсан мэргэжилтний хяналтын дор хамтран хийнэ.

6. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангиудад шаардлагатай ариутгал, цэвэрлэгээ, үйлчилгээг хийнэ. Амьсгалын бие даасан төхөөрөмж нэг бүрийн бүрдэл хэсгийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу задална. Задлах бүрдэл хэсгийг тусгайлан бэлдсэн гэрэлтүүлэг бүхий зөвлөн гадаргуутай ширээ болон тавцан дээр нүүрний хамгаалах баг, агаараар хангах хавхлаг, даралт тохиуулагч, нам даралтын болон өндөр даралтын хоолой, даралт хэмжигч, дуут дохио, агаар хадгалах сав, агаар хадгалах савыг бэхлэх үүргэвч гэсэн дараалалтай задаргааг хийвэл зохино. Задалсан бүрдэл хэсгийн эд ангийг нарийн шалгаж, цэвэрлэж, ариутгах бөгөөд гэмтэл илэрсэн эд ангийг шинээр солих буюу засварлаж тавина. Буцааж угсралдаа задаргаа хийсний дагуу хамгийн сүүлд авч

тавьсан эд анги, боолт, гайкаас эхлэн угсарч дуусаад 2 дугаар шалгалтыг хийнэ. Гуравдугаар шалгалтыг график, төлөвлөгөөний дагуу цаг тухайд нь хийж байхын тулд шалгалтанд оруулах амьсгалын бие даасан төхөөрөмжийн хуваарийг чиглэл хариуцсан мэргэжилтэн, ахлах засварчин нар бэлтгэл, бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр хийж урьдчилан танилцуулсан байна. Шалгалт хийсэн тухай амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин 3 дугаар шалгалт хийсэн тухай бүртгэлд тэмдэглэл хийж баталгаажуулна.

АБДТ-ийг хэрэглэхийн өмнөх шалгалт

7. АБДТ-ийг хэрэглэхийн өмнөх шалгалтыг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхийн өмнө амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь "Баг шалга" гэсэн хэсгийн ахлагчийн тушаалаар гүйцэтгэнэ. Энэ тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчид төхөөрөмжийг нуруундаа мөрлөсөн байх ба үүрэг гүйцэтгэх ажиллагааны үед хөдөлгөөнд саад болохооргүй өөртөө тохируулсан байна.

8. Шалгалтыг дэс дарааллын дагуу нэг минутаас илүүгүй хугацаанд хийнэ. Амьсгалын бие даасан төхөөрөмж гэмтэлгүй бүрэн ажиллагаатай хэрэглэхэд бэлэн болсон тухайгаа "ахлагч Бат төхөөрөмжтэй ажиллахад бэлэн, даралт 250 bar" гэж хэсгийн ахлагчид илтгэнэ.

9. Хэсгийн ахлагч биечлэн даралт хэмжигчийн заалтыг шалгаж, агаар хадгалах саван дахь хамгийн бага агаарын даралтыг тогтооно. Шалгалтаар гэмтэл илэрсэн буюу шалгалт хийгээгүй амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэхийг хориглоно.

Долоодугаар бүлэг

Амьсгалын бие даасан төхөөрөмжийг цэвэрлэх, ариутгах.

1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг дор дурдсан нөхцөлд цэвэрлэж, ариутгана.

1.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажилласны дараа (гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод болон дадлага, сургууль)

1.2. Шинээр хүлээж авсан амьсгалын бие даасан төхөөрөмж.

1.3. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч халдварт өвчнөөр өвчлөх.

1.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн гуравдугаар шалгалт хийх.

2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгалыг амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин биечлэн хийж гүйцэтгэнэ.

3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн дотор талыг спирт буюу уусмалд нортосон зөвлөн алчуураар арчина. Тэгэхдээ далдлагдсан буюу оёс бүхий хэсгийг сайтар арчих хэрэгтэй. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүх хавхлаг, пүрш ариутгагч уусмалд бүх хэсэг нь нортол 2-3 минутын хугацаатайгаар дүрж ариутгана. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн эд ангийг ариутгасны дараа бүлээн усаар угааж усыг шүүрүүлж хатаана.

4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг ариутгаж цэвэрлэх, үйлчилгээ хийхэд дараах бодис, шингэнийг хэрэглэнэ.

4.1. Цэвэр спирт, 80 хувийн борын хүчлийн уусмал, 0.1 хувийн бензолын уусмал, 0.5 хувийн марганц хүчлийн калийн уусмал, ариутгал, цэвэрлэгээний Sekumatic, sekusept, incidin, incidur, silicone tube grease зэрэг уусмал, шингэнийг хэрэглэнэ.

5. Хортой болон аюултай бодис, цацрагийн ба биологийн бохирдолтой орчинд аврах ажиллагаа явуулсан бүрэлдэхүүн ослын бүсээс гарч амьсгалын бие даасан төхөөрөмж, хамгаалах хэрэгслийг тайлахаас өмнө, төхөөрөмж, хамгаалах хэрэгсэлд бүрэн цэвэрлэгээ, ариутгал, идэвхжилт сулруулалтыг хийсний дараа тайлна.

Наймдугаар бүлэг
Хөтлөх баримт бичиг

1. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч бүрд нэгдүгээр хавсралтын дагуу бүртгэл хөтөлнө. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн бүртгэлийг засвар үйлчилгээний төв, засварын хэсэг дээр хөтөлж хадгална.

2. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн бүртгэлийг дараах албан тушаалтнууд эрхлэн хөтлөнө:

2.1. Салааны захирагч, бүлгийн дарга, амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин.

2.2. Салаа, бүлгийн орон тоонд ороогүй албан хаагчдыг амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин.

2.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах ангийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн асуудал хариуцсан албан хаагчид.

3. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах албан хаагчийн болон түүний хариуцсан амьсгалын бие даасан төхөөрөмжийн мэдээлэл мөн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал зэргийг нэгдүгээр хавсралтын хүснэгтийн дагуу хөтөлнө.

4. Амьсгалын бие даасан төхөөрөмжид хийгдэх шалгалтууд, агаар хадгалах савны цэнэглэлтийн байдал, төхөөрөмжтэй ажилласан хугацааны тэмдэглэл, техникийн үзлэгийн бүртгэлийг хоёрдугаар хавсралтын дагуу хөтөлнө.

5. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэйгээр гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн хэсгийн ажиллагааг тооцох хуудсыг гуравдугаар хавсралтын дагуу хөтөлнө.

6. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хэсгийн ажиллах тооцоог дөрөвдүгээр хавсралтын дагуу хөтөлнө.

7. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн дуудлагаар ажилласан бүртгэл судалгааг тавдугаар хавсралтаар тус тус хөтөлнө.

Нэгдүгээр хавсралт

АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖ ЭЗЭМШИГЧИЙН КАРТ

Овог
Нэр
Төрсөн огноо
Албан тушаал
Цол
Ажилласан жил
Харьялал

Хариуцсан төхөөрөмжийн тухай мэдээлэл

Хариуцсан төхөөрөмжийн төрөл Үйлдвэрлэсэн огноо Ашиглалтад орсон огноо Төхөөрөмжийн дугаар	Хариуцсан төхөөрөмжийн төрөл Үйлдвэрлэсэн огноо Ашиглалтад орсон огноо Төхөөрөмжийн дугаар	Хариуцсан төхөөрөмжийн төрөл Үйлдвэрлэсэн огноо Ашиглалтад орсон огноо Төхөөрөмжийн дугаар
---	---	---

Эрүүл мэндийн үзлэгийн тэмдэглэл

Эрүүл мэндийн үзлэгт орсон огноо		Эрүүл мэндийн үзлэгт орсон огноо.....		
	Тэмдэглэл	Гарын үсэг		Тэмдэглэл
Сүрьеэз- Мэдрэл- Дотор- Мэс засал- Чих хамар хоолой- Нүд- Арьс өнгө-			Сүрьеэз- Мэдрэл- Дотор- Мэс засал- Чих хамар хоолой- Нүд- Арьс өнгө-	
Эрүүл мэндээр төхөөрөмжтэй ажиллаж болно, болохгүй (доогуур нь зур) Болохгүй шалтгааныг тодорхой бичнэ. Эрүүл мэндийн үзлэгийн комиссын дарга АБДТ-ний засварчин			Эрүүл мэндээр төхөөрөмжтэй ажиллаж болно, болохгүй (доогуур нь зур) Болохгүй шалтгааныг тодорхой бичнэ. Эрүүл мэндийн үзлэгийн комиссын дарга АБДТ-ний засварчин	

Хоёрдугаар хавсралт

**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН
ТЕХНИКИЙН ПАСПОРТ**

Ашиглалтад орсон огноо	АБДТ-ний дугаар	АБДТ-ний серийн дугаар	Шалгалт хийсэн огноо
			Хэддүгээр шалгалт хийсэн
			Хийгдсэн засварын терел, сольсон эд ангийн нэр
			Төхөөрөмжтэй ажилласан гамшиг, аюулт үзэгдэл, осол, гол түймэр сургуулийн дугаар
			Төхөөрөмжийн ажилласан хугацаа цаг, минут
			Агаар хадгалах сав цэнэглэсэн огноо
			Агаар хадгалах савны дараалт
			Шалгалт, буртгэл хийсэн албан хаачийн гарын үсэг
			Хянасан албан хаагчийн гарын үсэг

Гуравдугаар хавсралт
**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ХЭСГИЙН
АЖИЛЛАГАА ТООЦОХ ХУУДАС**

д/д	Анги салбарын дугаар	Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг			Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүний нэрс	Тайлбар
		Ажиллаж байгаа	Амарч байгаа	Нөөцөнд		
		Төхөөрөмж хэрэглэсэн	Голомтоос гaraх хугацаа	Аюулгүй байдлыг хангах хэсэгт ирсэн хугацаа	Эхэлсэн цаг Дуусах цаг	Эхэлсэн цаг Дууссан цаг

Дөрөвдүгээр хавсралт
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХЭСГИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨТЛӨХ ХҮСНЭГТ

д/д	Анги, салбарын дугаар	АБДТ-тэй ажиллах хэсгийн албан хаагчдын тоо	Голомтод орсон албан хаагчдын тоо	Голомтоос гарсан албан хаагчдын тоо	Хамгийн бага агаарын даралтын заалт	АБДТ-тэй ажиллах хэсгийн голомтод ажиллах хугацаа

Тавдугаар хавсралт

**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ
АЖИЛЛАСАН БҮРТГЭЛ**

Төхөөрөмжтэй ажилласан огноо	Ямар төрлийн төхөөрөмж	Төхөөрөмжийн дугаар	Төхөөрөмжтэй ажилласан гал түймэр, аюулт үзэгдэл, осол, гал түймэр сургуулийн дугаар	Төхөөрөмжтэй ажилласан цаг, минут	Тэмдэглэл хөтөлсөн албан хаагчийн гарын үсэг

---оОо---